

Шороот овогт Сэрсэнгийн Чогсом



Сэрсэнгийн Чогсом нь Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг болох Шороот хэмээх газарт идээ цагаа дэлгэрсэн зуны дунд сард эх Сэрсэнгийн 3-р хүүхэд болон төрсөн. Үхэр жилтэй. Таана ногооны үнэр ханхалсан тал сайхан нутагтаа тоглож өссөн бөгөөд, сайхан эх эцэг, ахан дүүс, нутаг усны зон олны хайр ивээлээр өдий зэрэгт хүрсэн билээ. Хүүхэд ахуй насаа хонь мал хариулаж, даага шүдлэн эдэлгээнд сургах, хурдан морь унах, өглөө эртлэн босож адуунд явж ирэх, унага татаж гүү саалгах зэрэг аахар шаахар ажлыг гүйцэтгэж эрхиш малын дөртэй болсондоо. Манайх тэр үед тухайлбал миний ээж жинхэнэ айрганий сайханыг үйлдвэрлэж байсныг нутгийн ард түмэн бахархдаг байсныг дурьдалтай. С.Чогсом нь Дэлгэрцогт суманд ерөнхий боловсролын бүрэн дунд боловсрол эзэмшсэн бөгөөд 1970 онд Улаанбаатар хотын Санхүү Эдийн Засгийн Сургуулийг Аж үйлдвэрийн нягтлан бодогч мэргэжлээр, 1989 онд МУИС-ийг

Худалдааны нягтлан бодогч эдийн засагч мэргэжлээр тус тус дүүргэсэн. Ажлын гараагаа аймгийн хүнсний үйлдвэрээс эхэлж орлогч бөгөөд ерөнхий нягтлан бодогчоор 1970-1981 оны 09 дүгээр сар хүртэл ажилласан байсан. Тэр үед төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг үйлчилж байсан бөгөөд хүнсний үйлдвэр аймгийн төсвийн орлогын гол эх үүсвэрийг архины гүйлгээний татвараар бүрдүүлж орлогийн төлөвлөгөөг жил дараалан биелүүлдэг байлаа. Хүнсний үйлдвэр нь төрийн яамдаас явуулдаг бүртгэл тооцооны үзлэг шалгалтанд тогтмол амжилттай дүн үзүүлдэг байсан. 1991 оны 09 дүгээр сараас МУ-ын засгийн газрын шийдвэрээр бүртгэл тооцооны ажлыг механикжуулах зорилгоор төсөвт газруудын нягтлан бодогч нарыг нэгтгэж аймгийн ардын дептатуудын хурлын гүйцэтгэх захиргааны дэргэд төвлөрсөн нягтлан бодох ангийг байгуулахад С.Чогсомыг тус ангийн анхны дарга ерөнхий няглан бодогчоор томилон ажиллуулсан бөгөөд, тус ангийн бүтэц зохион байгуулалтын ажлыг хийж холбогдох дээд байгууллагаар батлуулан ажилласан.

С.Чогсом нь: 1985-1994 онуудад аймгийн санхүүгийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн, аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчоор, 1994-1999 онуудад аймгийн санхүүгийн хэлтсийн дарга, 1999-2003 онуудад Улсын санхүүгийн хяналт шалгалтын газар Улсын болон ахлах байцаагч, 2003-2010 онуудад Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт Улсын ахлах байцаагч, 2010-2022 оны 09 сарыг дуустал СЭМҮТ-д санхүүгийн дотоод хяналтын аудиторроор ажилласан. С.Чогсом нь Монгол төрийн албанд тасралтгүй 52 жил ажилласан байна. Монгол Улсын Ширээний теннисны спортын мастер юм.

С.Чогсомын ажлын бүтээлийг үнэлж Монгол улсын засгийн газрын шагналд:

-Санхүү банкны тэргүүний ажилтан

- Төрийн албаны тэргүүний ажилтан
- Төрийн хяналт шалгалтын тэргүүний ажилтан
- Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан
- Мэргэжлийн хяналтын тэргүүний ажилтан
- Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан
- Ардын хувьсгалын 70,80,90,100 жилийн ойн медалууд
- Хөдөлмөрийн хүндэт медаль
- Алтан гадас одон

-Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор тус тус шагнагдсан бөгөөд 2021 онд МУ-ын ерөнхийлөгчийн зарилгаар Монгол Улсын Гавьяат Эдийн Засагч цолыг хүртсэн байна.

Жич: Төрөлх нутаг Дэлгэрцогт сум байгуулагдсаны 80,90 жилийн ойн ажлыг зохион байгуулах, цаг агаарын бэрхшээл тохиолдох зэрэг цаг үеийг ажил, соёл олон түмний ажил, хандив тусламж цуглуулах зэрэгт Улаанбаатар хот дахь сумын нутгийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүний хувьд идэвхитэй оролцож байснаа хэлье.



МУ-ын гавьяат нисгэгч Д. Байгаль



Миний эцэг Сүхийн Даржаа нь Завхан аймгийн Алдархаан сумын харъяат. Дунд сургууль төгсөөд Зөвлөлт Холбоот Улсын Сасово хотын нисэхийн дунд сургуульд орж суралцсан. 1964 онд сургуулиа амжилттай төгсөөд “МИАТ” компанид Ан-2 онгоцны нисгэгчээр ажлын гараагаа эхэлсэн. Ан-2, Ил-14, Ан-24, Ан-26 онгоцны 2-р нисгэгч, Агаарын хөлгийн даргаар ажиллаж байгаад 1993 онд гавьяаны амралтанд гарсан.

Миний эх Лувсанжамцын Цагаантоого нь Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын харъяат. Дунд сургууль төгсөөд ‘Анагаах ухааны дээд сургууль’-д элсэн суралцаж хүний их эмчийн мэргэжил эзэмшсэн. Хорооны эмчээс ажлын гараагаа эхэлж Ардын армийн 150; 107-р ангиудад их эмч, эмнэлгийн албаны даргаар ажилласан. 1976 оноос ‘Цэргийн төв эмнэлэгт’ их эмч, дотрын тасгийн дарга, онош зүйн кабинетийн эрхлэгч зэрэг удирдах албан тушаалд ажиллаж дэд хурандаа цолтойгоор гавьяаны амралтанд гарсан.

Аав ээж хоёр маань 1965 онд гэр бүл болж 1967 онд ууган хүү нь болж би мэндэлсэн. Бага насаа өвөө эмээгийн цэцэрлэгээр хүмүүжсэн. 1985 онд Нийслэлийн 6-р дунд сургууль төгсөөд АА-н 029-р ангид цэргийн алба хаасан. 1986 онд тухайн үеийн ЗХУ-ын ‘Фрунзе’ хотын цэргийн нисэхийн дунд сургуульд элсэн орж суралцсан. 1989 онд сургуулиа төгсөөд АА-н 137-р ангид сөнөөгч МиГ-21 онгоцны нисгэгчээр хувиарлагдсан. 1990 онд Хилийн цэргийн 0200-р ангид нисдэг тэрэгний нисгэгч бэлтгэх курст орж төгссөн.

1990 онд МИАТ компанид орж Ми-8 нисдэг тэрэгний 2-р нисгэгч, агаарын хөлгийн даргаар ажилласан. 2008 онд ОХУ –ын Санкт- Петербургийн иргэний нисэхийн академийн дэргэдэх иргэний нисэхийн удирдах ажилтан болон мэргэжлийн багш бэлтгэх курсийг төгсөж багшлах эрх авсан. 2010 онд АНУ-ын Техас мужийн Даллас хотын “Eurocopter”, Колорадо мужийн Денвер хотын “Flight Safety – International” зэрэг нисэхийн академиудад орчин цагийн барууны агаарын хөлөгүүд дээр шилжин суралцах сургалтанд хамрагдаж ЕС-145, Н-125, Н-130 маягийн нисдэг тэрэгнүүд дээр нисэх эрх авсан. 2022 онд Францын Марсель хотын сургалтын төвд суралцан ‘CABRI’ загварын нисдэг тэргэн дээр нисэх эрх авсан.

1990 оноос өнөөдрийг хүртэлх энэ хугацаанд төр засгийн тэргүүн болон түүнтэй адилтгах гадаадын төр засгийн төлөөлөгчдөд үйлчлэх тусгай үүргийн нислэгүүд, агаараас эрэн хайх авран туслах нислэгүүд, зуд турхан, ой хээрийн түймэр, кино зураг авалт, ан амьтан тоолох, ан хийх, шүхэрчид буулгах, геологи хайгуул, эмнэлэгийн түргэн тусламж, авто машины уралдаануудад үйлчлэх, тэдгээрийн зураг авалт, нисдэг тэргийг ОХУ-д их засварт нисгэж хүргэх, буцаан авчрах компаний дотоод болон жуулчдад үйлчлэх захиалгат нислэгүүдийг амжилттай гүйцэтгэж Ми-8Т, Ми-171, ЕС-145, Н-130, Н-125, Кабри зэрэг нисдэг тэрэгнүүд дээр агаарт нийт 8915 цагийн нислэгийн үүрэг гүйцэтгэж 1,800,000 км агаарын замыг туулан 8406 хөөрөлт буултыг аюулгүй гүйцэтгэж байна.

Ам бүл 6. Эхнэр 4-н хүүхдийн хамт амьдардаг. Эхнэр Д. Алтангэрэл хувийн байгууллагад ажиллаж байгаад одоо тэтгэвэртээ суусан. Эхнэрийн талынхан нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын харъяат Дооровын Дашзэвэг хэмээх Ардын хувьсгалын партизаны үр хойчууд байдаг. Том хүү өвөө болон аавынхаа мэргэжлийг удам дамжин өвлөж одоо МИАТ компанид “Boeing- 737” онгоцны нисгэгчээр ажилладаг. Дунд хүү Австралид гэр бүлийн хамт амьдардаг. Охин МУИС-ийг эдийн засагч мэргэжлээр төгсөөд одоо хувийн компанид ажилладаг. Бага хүү АНУ-ын Сан- Диего хотод мөн нисэхийн дунд сургуульд суралцдаг.

- 2005 онд Монголын иргэний агаарын тээврийн тэргүүний ажилтан
- 2008 онд Хөдөлмөрийн хүндэт медаль
- 2017 онд Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон
- 2021 онд Монгол улсын гавъяат нисгэгч цол тэмдэгүүдээр шагнагдаж байсан.

Улсын аварга малчин Цэнджавын Болоож

Цэнджав овогтой Болоож нь 1937 онд төрсөн.Бага наснаасаа эхлэн мал маллах арга ухаанд суралцаж мал маллаж байгаад 1956 онд эх орноо хамгаалах үйлс эр цэргийн албанд мордон цэргийн албыг нэр тэртэй хаасан билээ.

Эхнэр Д.Цэрэннадмидтайгаа 40 гаруй жил хамт амьдарч 7 хүүхэд төрүүлж өсгөхдөө хоорондоо эвтэй найртай олон түмэн цугласан цайтай ундтай амгалан сайхан хүмүүс байсан.Үр хүүхдүүд нь одоо энх тунх эцэг эхийнхээ өвлүүлсэн малч удмыг залгамжлан мал маллан амьдрал ахуйгаа дээшлүүлэн өнөр өтгөн сайхан амьдарцгааж байна даа.

Цэргээс халагдаж ирээд нэгдэлд 1959 оноос мал маллаж,мал аж ахуйг отор нүүдлийн аргаар эрхлэн хөтөлдөг амьдралын уламжлалт арга ухааныг хойч залуу үед зааж сургах өвлүүлэх ажлыг эзэмшүүлэн иржээ.

Жилийн дөрвөн улиралд бэлчээр сонгон нутаг сэлгэн нүүдэллэн малынхаа сүү сааль,ноос ноолуурыг бүрэн авч,хашаа хороо,худаг усаа засаж янзалж цэгцэлсэн үлгэр жишээ ард түмэндээ хүндлэгдсэн малчин өрх байсан.

Ц.Болоож нь хурдан морь уяж сойх арга ухааныг сайн эзэмшин аймаг,сумын наадамд олон сайхан хурдан хүлгүүдийг хурдлуулан түрүүлж айрагдуулж байсан сайн уяач байлаа.Мал маллах хугацаандаа “Энх мэнд сүрэгтэн” өрхөөр 10 гаруй удаа шалгарч байсан.

Мал маллахаас гадна ан ав агнах ажилд мэргэшсэн улсын аварга анчин байлаа.Худалдаа бэлтгэлийн ангийн түүхий эд бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлэхэд гэрээ байгуулан идэвх санаачлагатай ажиллан төлөвлөгөө нормоо давуулан биелүүлж байсан.

Улс нийгэмд үр бүтээлтэй хөдөлмөрлөснийг төр засаг үнэлэн 5,6,7-р таван жилийн гавшгайч,Хөдөлмөрийн хүндэт медаль,Алтан гадас одон,Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон,Ардын хувьсгалын 50,60,70,80 ойн медалиуд 1991 онд Монгол улсын “Аварга малчин”цолоор тус тус шагнагдаж байжээ.

БУРИАД СУРЫН УЛСЫН МЭРГЭН, ҮНДЭСНИЙ СУРЫН СПОРТЫН МАСТЕР ЗАГДХОРОЛЫН ПЭРЭНЛЭЙМАА



Загдхорол овогтой Пэрэнлэймаа нь 1990 онд Дэлгэрцогт суманд төрсөн. МГСС-тай 4-р сургуулийг 2008 онд төгсөөд улмаар ХААИС-ийг 2012 онд инженер мэргэжлээр дүүргэсэн. Дунд сургуульд байхаасаа үндэсний сурын спортыг сонирхон хичээлэлж эхэлснээр Өсвөр үед: 1. 2003 он Дэлгэрцогт сум байгуулагдсаны 80н жилийн ойн баяр наадам - 4р байр 2. 2003 оны Дундговь аймгийн хаалтын харваа - 3р байр 3. 2004 он Дэрэн сум байгуулагдсаны 80н жилийн ойн баяр наадам - 3р байр 4. 2004 он Өлзийт сум байгуулагдсаны 80н жилийн ойн баяр наадам - 2р байр 5. 2006 он “Уяхан замбуу тивийн наран” уртын дууны олон улсын бага наадам Задгай театрын цогцолборын нээлтэнд зориулсан хувийн цуваа харваа - 3р байр, багийн харваа

- 1р байр 6. 2006 он Дэлгэрцогт сумын баяр наадам - 2р байр 7. 2007 он Үндэсний сурын ААШТ - 3р байр 8. 2007 он Дундговь аймаг байгуулагдсаны 65 жил, ЗАВА ДАМДИНЫ мэндэлсний 140 жилийн ойн баяр наадмын сурын харваанд 3-р байр 9. 2007 он Хөнгөн атлетикийн ААШТ 400м-ийн төрөлд 2-р байр 10. 2008 он МУ-ын рекордч, спортын мастер Ц. Мөнх-Эрдэнийн нэрэмжит ААШ хөнгөн атлетикийн тэмцээн 100м-ийн төрөлд 3р байр 11. 2008 он Дэлгэрцогт сумын 85н жилийн ойн баяр наадам 3-р байр, 1. 2009 он Дундговь аймаг байгуулагдсаны 67 жилийн ойн баяр наадмын сурын харваанд 1-р байр “Аймгийн мэргэн” цол 2. 2010 он “Онолын механик”-ийн улсын III-р олимпиад 2-р байр 3. 2014 он Дундговь аймаг байгуулагдсаны 73 жил, Сайнцагаан сум байгуулагдсаны 90 жилийн ойн баяр наадмын сурын харваанд 4-р байр 4. 2015он Дундговь аймаг байгуулагдсаны 74 жил, Мандалговь хотын 50 жилийн ойн баяр наадмын сурын харваа 5-р байр 5. 2016 он Үндэсний сурын харвааны эмэгтэй багийн УАШТ 5-р байр 6. 2016 он УБ хотын АШТ хасаа харвааны төрөлд 4-р байр 7. 2016 он Үндэсний сурын харвааны багийн УАШТ 2-р байр, хувийн цуваа харваанд 40-н сумнаас 35 онож СПОРТЫН МАСТЕР цолны болзол хангаж хувийн цуваа харваанд 5-р байр 8. 2016 он Их Эзэн Чингис Хааны мэндэлсний 854 жилийн ойн харваанд 3-р байр 9. 2017 он Дундговь аймгийн нээлтийн харваа 1-р байр 10. 2017 он Дундговь аймгийн отго харваа 2-р байр 11. 2017 он Хятад улсын GOLMUD хотод болсон олон улсын харваа “Холч харваа”-ны тарөлд 3-р байр 12. 2018 он ОБЕГ-н аврагч спорт хороо МУ-ын мэргэн Д.Цэцэгийн нэрэмжит Эрч багийн нээлтийн харваа

4-р байр 13. 2018 он Харваачдын наадмын “Холч харваа”- ны төрөлд 1-р байр 14. 2018 он Говийн бүсийн чуулга харваа 1-р байр 15. 2018 он Үндэсний сурын ууган мастер Ш.Жамбасамбуу агсны нэрэмжит харваа 4-р байр 16. 2018 он Монголын Үндэсний Спортын VI-р их наадам “Уламжлалт харваа”-ны төрөлд 3-р байр 17. 2018 он Дундговь аймаг Отго харваа 3-р байр 18. 2019 он Үндэсний сурын холбооны нэрэмжит “Холч харваа”-ны тэмцээнд 3-р байр 19. 2019 он УБ хотын АШТ-нд нийлбэр дүнгээр 2-р байр, хана харвааны төрөлд 3-р байр 20. 2019 он Сонгинохайрхан уулын тахилга наадам 2-р байр 21. 2019 он эмэгтэй багийн УАШТ 2-р байр 22. 2019 он Буриад сурын багийн УАШТ 4-р байр 23. 2019 он Дорнод аймаг Зүүн бүсийн хурд-2019 баяр наадмын “Буриад сур”-ын төрөлд 1-р байр “Аймгийн мэргэн” цолны болзол хангасан 24. 2019 он Чингэлтэй хайрхан тахилга наадмын сурын харваанд 1-р байр 25. 2019 он Буриад сурын Улсын хаалтын харваа 1-р байр “СПОРТЫН ДЭД МАСТЕР” цолны болзол хангасан 26. 2022 он Дундговь аймаг АШТ 2-р байр 27. 2022 он эмэгтэй багийн УАШТ 4-р байр 28. 2022 он Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улсын 815,816, Ардын хувьсгалын 100,101-н жилийн ой, Үндэсний их баяр наадмын Буриад сурын харваанд 1-р байр, Буриад сурын **УЛСЫН МЭРГЭН** цол хүртсэн.



ҮНДЭСНИЙ СУРЫН СПОРТЫН МАСТЕР БАТААГИЙН УРАНГОО

Батаа овогтой Урангоо нь Дэлгэрцогт суманд төрсөн.2004 онд 8-р анги,2006 онд Эрдмийн цогцолбор сургууль,2010 онд Их засаг их сургууль, 2017 онд МҮИС-ийн уул уурхайн инженерээр магистр тус тус төгссөн.

2018 оноос “Баян баяг”ХХК-ны ерөнхий захирлаар ажиллаж байна.

2010 онд Ц.Даваасамбуутайгаа гэр бүл болж 3 хүүхэд төрүүлж өсгөсөн.

Өвөг дээдсээс өвлөгдөн ирсэн үндэсний сур харваагаар 2017 оноос эхлэн хичээллэж

- 2017,2018 оны аймгийн аварга

- 2018 онд багаараа улсын аварга, говийн бүсийн

чуулга харваанд багаараа тэргүүн байр, цуваа харваанд хүрэл медаль,багаараа улсын аваргын тэргүүн байр

- 2019 онд Улаанбаатар хотын аваргын мөнгөн медаль, харваачдын баярт холч харваанд 365 метр харваж тэргүүн байр
- 2022 оны эмэгтэй багийн хүрэл медаль
- Өвөрмонголд болсон олон улсын оюутны спортын наадамд саранбай харваагаар хүрэл медаль
- Аймгийн наадмын харваанд түрүүлж "Аймгийн мэргэн" цол
- Үндэсний спортын 6-р их наадамаар "Спортын мастер"болсон.

Үндэсний сур харвааг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулж явна.

ОЮУНЫ ИХ СПОРТЫН АХ ДҮҮ ГУРВАН МАСТЕР



Цэрэнбямба овогтой Цэрэнбямба овогтой Энхзаяа 1986.07.27 нд Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд төрсөн. 100 буудалт даамын спортын мастер Өсвөрийн үеийн улсын аварга шалгаруулах тэмцээний хошой алт Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээний хошой алт Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний хошой алт Насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээний мөнгө, хүрэл медальт 2022 оны Ази тивийн Турк даамын тэмцээний алтан медальтай.



Цэрэнбямба овогтой Эрдэмбилэг 1984.05.25 нд Дундговь аймгийн Мандалговь хотод төрсөн 100 буудалт даамын спортын мастер. Дундговь аймгийн 10 удаагийн аварга. 2022 оны Ази тивийн хүрэл медальт. Одоо Монголын даамын холбооны ерөнхийлөгчийн сонгуульт ажил хийж байна.



Цэрэнбямба овогтой Отгонбилэг. 1997.03.18 нд Дундговь аймгийн Мандалговь хотод төрсөн. 100 буудалт даамын Олон улсын мастер Өсвөр үеийн Ази тивийн хошой алт Өсвөрийн үеийн улсын Аварга шалгаруулах тэмцээний хошой алт Залуучуудын УАШТ хошой алт Оюутны улсын аварга шалгаруулах тэмцээн 3 удаагийн аварга (оюутан байх бүх хугацаандаа) Насанд хүрэгчдийн улсын хошой мөнгө. 2019 онд Ази тивээ төлөөлж Насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон Монгол улсын 4 дэхь тамирчин.

ҮНДЭСНИЙ СУРЫН СПОРТЫН МАСТЕР



1. Овог нэр
- Баасан овогтой Иш-Ёндон
2. Цол, зэрэг
- Үндэсний сур харвааны Спортын мастер, Аймгийн Онч харваач
3. Харьялал
- Дундговь аймгийн Дэлгэрцогт сум, Дундговь аймгийн Үндэсний сурын холбоо, “Онч мэргэн” баг, “Хос төгөл” ХХК - ны харваач
4. Амжилт
- 2019 онд Говийн бүсийн аварга шалгаруулах чуулга харваанд багаараа 2-р байр, мөнгөн медаль
- 2020 онд Дундговь аймгийн аварга шалгаруулах үндэсний сурын харваанд 3-р байр, хүрэл медаль
- 2021 онд Залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээнд 2-р байр, мөнгөн медаль, спортын мастер цол
- 2021 онд Улсын Аварга шалгаруулах тэмцээнд баг, байгууллагын дүнгээр 4-р байр, хүрэл медаль
- 2021 онд Дундговь аймаг байгуулагдсны 79 жилийн ойн харваанд 4-р байр, Аймгийн Онч харваач цол
- 2021 онд Аймгийн аварга шалгаруулах харваанд 3-р байр, хүрэл медаль
- 2022 онд Мөсний сур харвааны Улсын аварга шалгаруулах тэмцээнд багаараа шагналт 4-р байр

- 2022 онд Холимог багийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд багаараа 1-р байр, алтан медаль
- 2022 онд Үндэсний спортын 7-р наадамд багаараа 2-р байр, мөнгөн медаль
- 2022 онд Эрэгтэй багийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд багаараа 3-р байр, хүрэл медаль
- 2022 онд Улсын аварга шалгаруулах тэмцээнд баг, байгууллагын дүнгээр 2-р байр, мөнгөн медаль
- 2022 онд Говийн бүсийн аварга шалгаруулах чуулга харваанд багаараа 1-р байр, алтан медаль

ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВААНЫ ДЭД МАСТЕР

ЖАМСРАНЖАВ ДОРЖДУЛАМ



Жамсранжавын Дорждулам нь 1988 оны 3-р сарын 3 нд Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд төрж өссөн.

1996-1999 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 8 жилийн сургууль

1999-2006 онд Дундговь аймгийн Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай сургууль

2006-2010 онд Монгол Улсын Их Сургууль, Эдийн Засгийн Сургууль

2010-2014 ХААН БАНК- теллер, нягтлан бодогч

2015-2017 Харилцааны ур чадварын институт- нягтлан бодогч /ерөнхий менежер/, мөн

БСШУСЯ-Дээд боловсролын шинэчлэлийн төсөл дээр ажилласан.

2018- “Наран косметикс “ ХХК маркетингийн менежер-ээр тус тус ажилласан.

Үндэсний сурын харваагаар 2016 оноос хичээллэхээр Онцгой байдлын ерөнхий газар АВРАГЧ биеийн тамир спортын газрын харьяа “ЭРЧ” клубт тамирчнаар орж спортын мастер Г.Мөнхсайхан багшийн удирдлаганд бэлтгэл хийж эхлэсэн. 2019 онд Дундговь аймгийн үндэсний сурын баг байгуулагдахад нутгийн “ЦАХИУР” багт харваж эхэлсэн.

2017 онд МҮХХ-ны анхны эмэгтэй ШИЛДЭГ ШҮҮГЧ шагнал

2018 онд Улсын нээлтийн харваагаар Спортын Дэд Мастер цол , улсын чансааны 42-т,

2019 онд УАШТ 5-р байр , улсын чансааны 17-д,

2020 онд Улсын чансааны 25-д

2021 онд Аймгийн баяр наадмын харваанд 1-р байр эзэлж Аймгийн мэргэн цол,
Аймгийн засаг даргын ЖУУХ БИЧИГ

2022 онд Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн-1 -р байр

Спортын 7-р их наадамд багаараа-2-р байр

Эмэгтэй багийн аварга шалгаруулах тэмцээнд багаараа-4-р байр

Говийн бүсийн чуулга харваанд багаараа-1-р байр тус тус эзлэсэн бөгөөд үндэсний сурын харваанаас гадна буриад сур харваа, уламжлалт харваа, зэвт харваа, саранбай харваагаар Улс, аймгийн, баг, клубын нээлтийн харваа, отго харваа, аварга шалгаруулах харваа гээд өнөөдрийн байдлаар 50 гаран тэмцээнд байр эзэлж алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн байна.

МОНГОЛ УЛСЫН СПОРТЫН МАСТЕР Д.СЭД



Должин овогтой Сэд нь 1947 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд төрсөн. Ам бүл 3-уул амьдардаг. Д.Сэд нь бага насаа эцэг эхийн гар дээр мал маллан 1955 онд Дэлгэрцогт сумын сургуульд элсэн орж, 1959 онд 4-р анги төгсөөд өөрийн ах Д.Базаргүрүүг даган адуучин болох анхны гараагаа эхэлсэн.

1965-1968 он хүртэл ямаа тууж байгаад, 1969-1971 оны хооронд акт тууж, 1972-1992 он хүртэл тасралтгүй 20 жил адуу малласан. Мөн 1981 онд 35 эмнэг сургаж спортын мастер болсон. Адуу маллах хугацаандаа “Сүм хөх бүрд”-ийн амралтад айраг нийлүүлж ажиллахдаа норм төлөвлөгөөг тогтмол биелүүлж ирсэн.

- 1981 онд спортын мастер
- 2019 онд Аймгийн хүндэт тэмдэг
- 2020 онд Алтангадас, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медал
- 2022 онд аймгийн 80 жилийн ойн медал

МОНГОЛ УЛСЫН МОРЬ ЦОЛЛООЧ, ҮНДЭСНИЙ БОЛОН МӨСӨН СУРЫН ХАРВААНЫ СПОРТЫН ДЭД МАСТЕР



Баасангийн Жанчивдорж нь 1987 онд Дэлгэрцогт суманд төрсөн. Бага наснаасаа аавынхаа уяж сойсон хурдан морийг унаж, уяаны ажилд туслаж өссөн. Анх хурдан морь цоллох эрдмийг аав Л.Баасангийн заавар зөвлөгөөгөөр сурч эзэмшсэн. Улсын баяр наадам болон Засгийн газрын тогтоолтой улсын бүсийн уралдаан, аймгийн баяр наадам, шигшмэл хурд, аймгийн бүсийн уралдаанууд, сумдын наадам зэрэг олон наадамд нутаг усныхаа нэрийг өндөрт гарган хурдан

хурц хүлэг морьдын цолыг дуудсан байна. Улмаар 2015 онд **“МОНГОЛ УЛСЫН МОРЬ ЦОЛЛООЧ”** хэмээх эрхэм цолыг хүртсэн. Мөн хурдан морь цоллох өв соёлыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд Цагаандэлгэр сумын уугуул МУМЦ Д.Цэрэндаваа, Луус сумын уугуул “морины” хэмээх Ц.Баатар ах зэрэг хүмүүс маш их дэмжлэг үзүүлсэнийг дурдах хэрэгтэй.

2018 оноос нутгийн эгч болох аймгийн мэргэн, спортын мастер Дамбаагийн Амаарагчаагийн удирдлага дор үндэсний сурын харваагаар эрчимтэй хичээллэж улс, аймгийн чанартай харвуул наадам, тэмцээнд шагналт байранд удаа дараалан шалгараад байна.

Амжилтуудаас дурдвал:

- 2019 оны Залуу харваачдын үндэсний сурын харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнд хүрэл медаль
- 2020 оны Мөсөн сурын харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнээс **спортын дэд мастер цол** /Дундговь аймгаас төрөн гарсан мөсөн сурын анхны 3 мастерын нэг/
- 2020 оны Улсын их баяр наадмын үндэсний сурын харваанд **спортын дэд мастер цол**
- Аймгийн чанартай харвуул тэмцээнд 7 удаа, сумын болон бусад харвуул наадам тэмцээнд 10 гаруй удаа шагналт байранд шалгарсан байна.



МОНГОЛЫН ДИФ ОЛИМП ХОРООНЫ ТАМИРЧИН, ОУХМ БАЯНМӨНХ ОВОГТОЙ НАВААНЖАМЦ

Баянмөнх овогтой Наваанжамц нь 1991.10.29-нд Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд төрсөн. 2001 онд Нийслэлийн 29-р тусгай сургуульд элсэн орж, 2010 онд 11-р ангийг төгссөн. Мөн 2010 онд “Олимп” дээд сургуулийн Жудо бөхийн дасгалжуулагч багшийн ангид элсэн орж 2014 онд төгссөн. Тэрээр багаасаа бөхийн спорт болон бусад биеийн тамир спортод дур сонирхолтой, авьяастай хүүхэд байсан. Одоо айл гэрийн ноён нуруу, аав хүний эрхэм үүргээ биелүүлж, эхнэр, 3 хүүхдийн хамт ам бүл тавуулаа Улаанбаатар хотод ажиллаж, амьдарч байна.

Түүний амжилтаас дурьдвал:

2006-2009 онд Дэлгэрцогт сумын сургуулийн болон 29-р тусгай дунд сургуулийн биеийн тамирын тэмцээн уралдаанд тогтмол амжилттай оролцдог.

Тайваны Тайпэй хотод болсон Зуны 21-р Дифлимкийн жудо бөхийн 60кг-н жинд хүрэл медаль хүртэж Монгол улсынхаа нэрийг Дэлхийн тавцанд гаргасан бахархалт хүү юм. Энэхүү амжилтыг нь төр засгаас өндрөөр үнэлж: “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор шагнаж, урамшуулсан.

- 2009 онд Монголын үндэсний Олимкийн хорооны “Олимкийн алдар” одон
- 2009 онд Биеийн тамир спортын улсын хорооны “Спортын алдар” тэмдэг
- 2009 онд Хүүхдийн төлөөх газрын “Оны шилдэг хүүхэд” алтан медаль
- 2009 онд Хадбаатарын нэрэмжит бөхийн тэмцээнд “Уран барилдаанч” бөхөөр шалгарч хүрэл медаль
- 2009 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын “Тэргүүний тамирчин сурагч” тэмдэг
- 2010 онд Сонсголын бэрхшээлтэй иргэдийн холбооны “Оны шилдэг залуу” өргөмжлөл
- 2012 онд Монголын дүлийн иргэдийн жудо бөхийн улсын аварга шалгаруулах анхдугаар тэмцээний мөнгөн медалиар тус тус шагнагдсан байна.

Б.Наваанжамц нь 2013 оны Зуны 22 дахь Дифлимкийн наадмаас жудо бөхийн 73кг жинд хүрэл медаль хүртэж, Дифлимкийн наадмын хошой хүрэл медальтан болсон.

2015 онд Ази Номхон далайн орнуудын Диф спортын VIII наадмаас жудо бөхийн 81кг жинд мөнгөн медаль авсан. 2016 оны 7сарын 18-22ны өдрүүдэд Туркийн Самсун хотноо зохиогдсон сонсголын бэрхшээлтэй иргэдийн тулааны урлагийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жудо бөхийн 81кг жинд алтан медаль, мөн багийн төрөлд мөнгөн медаль хүртсэн.

2018 онд Турк улсад болсон 23-р Дифлимбийн наадамд 81кг жинд хүрэл медаль хүртсэн.

2018 онд ОУХМ цол тэмдэгээр шагнагдсан.

2022 онд Бразилийн Кашиас До Сул хотноо болсон Зуны 24-р Дифлимбийн наадамд жудо бөхийн 81кг жинд барилдаж 5-р байр эзэлж, амжилтаа бататгасан.

Хэдийгээр хүнтэй ярилцах хэл яриа дутуу ч хүч чадал, авьяас билгээрээ Тив, Дэлхийд Монгол Улсынхаа нэрийг олонтаа мандуулсан тамирчин дүүдээ удахгүй “Гавьяат тамирчин” болохын ерөөл өргөө.

ТЭМЭЭНЭЭС ЭХТЭЙ-МОРИН ПОЛО



ДУРСАХ НЬ: 2004 онд Сумдын ЗДТГ-ын үйл ажиллагаанд ХШҮ хийхээр тухайн үеийн Аймгийн ЗД Орлогч Ш.Төрбатаар ахлуулсан ажлын хэсэг тус Дэлгэрцогт суманд ажиллан танай сумын ажил боломжийн байна. Гэхдээ эцсийн дүнг нэг үзүүлэлтээр дүгнэнэ гээд нэг хүндхэн даалгавар өгсөн нь “Тэмээн поло” Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд баг бүрдүүлж оролцох байлаа.

Ингээд бид ажилдаа орлоо Сумын засаг дарга Г.Бөхчулуун, Багийн засаг дарга Ю.Бавуудорж, Н.Загдхорол, Б.Баатарсүрэн за тэгээд л хамт олон, малчид эрвийж дэрвийхээрээ хөдөллөө.

Өвлийн тэсгэм хүйтэнээр 10-н хэдэн тэмээтэй сэтгэл нийлсэн баг тоглох нь байтугай нэрийг нь ч бараг дуулаагүй тэмээн положийн тэмцээнд оролцохоор аймаг зорьлоо. Анхны болоод ч тэрүү аймгийн удирдлага их ач холбогдол өгсөнийх ч хэлэх үү сумдын тэмээтэй жагсаал илтгэл, рапорт, ёслолын буудлага гээд тэмээ байтугай бид ч үзээгүй л юм болсоноор тэмцээн 2 зон болж эхэллээ. Хоёр дахь өдрийн орой гэхэд нөгөө зоноос Дэлгэрхангай манай зоноос Дэлгэрцогт сумд шалгарч аваргын төлөө аймгийг доргиосон юм болж байж манай сум “Аймгийн аварга” эрхэм алдарыг хүртсэнээр Полотой анх холбогдсон билээ.

Хойтон нь буюу 2005 онд дахин нөгөө тэмцээн маань улам өргөн дэлгэр ӨМӨЗО болон говийн 3 аймгийн баг тамирчид оролцоноор тэмцээн эхэлсэнч Дорноговийн Сайхандулааны “Ижий говь” шилжин явах цомоо аваад ирсэн багийг хэдэн минут хоцорсоноор тэмцээнд оролцуулалгүй хассанаар жаахан маргаан үүссэн юм. Үүнд гол рольтой хоёр шөвгөрсөн нөхөр байсны нэг нь миний бие нөгөө нь Дорно говь аймгийн

дасгалжуулагч Эрдэнэбилэг билээ.Энэ журмын нөхөр маань чи моринд дуртай хүн гэсэн Морин пологийн спорт гэж бас сайхан хөгжиж байгаа үүнд хойтон зун говио төлөөлж хамт оролцоё гэхэд нь баг ч үгүй морь ч үгүй байж за гэж тохиролцсон билээ.

2006 он цаг ногоо дэлгэрч би нөгөө пologoо ч мартчихсан байтал хэн нэгэн утасаар ярьсан нь Дорноговийн Эрдэнэбилэг найз маань моринд сайн 4 хүүхэд,эмээлтэй нь аваад Улаанбаатарт ир тэндээс нийлээд Хархорин явна гэдэг байгаа.Эр хүний итгэлийг даах л ёстой учраас З.Түвшинтөр,Г.Лхамхүү,Т.Жамсрандорж,З.Наранмандах гэсэн 4 хүүтэй автобусаар Улаанбаатар орон Драгон автобуудалаас Дорноговийн багтайгаа нийлэн эртний нийслэл Хархорин нутгийг зорьсоор шөнөдөж очлоо. Орхоны хөндийд өглөө ажих нь ээ тэр нутгийн залуус Морин поло гэдэг спортыг эрт мэдэрчихсэн түүнд сэтгэлээ зориулсан энд тэндгүй сайхан хөнгөрүүлсэн морьдоор бөмбөг цохиж хөөцөлдөх нь чадмаг харагдана.

Нутгийн айлууд морьд түрээслүүлдэг юм байна хүүхдүүдээ морьд авч бэлтгэлээ эхэллээ,Улаанбаатар,Архангай,Өвөрхангай,Булган гэх мэт нутгаас мөн дээр нь говийн хоёр аймгийн баг тамирчид цуглажээ.20-иод хоног бэлтгэл дадлага хийж,бас гадаад багш нар онол зааснаар өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээн эхэлж 2 өдөр өрсөлдөн 14 багаас Дундговийн баг 3-р байр эзлэн хүрэл медалиар энгэрээ мялаалаа.

2007 онд энэ багаараа дахин оролцон 3-р эзлэн медалийн төлөө тоглож байхад Аймгийн БСГазрын Ц. Сэрээнов даргатай хамт олон аялалаар явж байгаад тааран их л баярлацгааж байж билээ.

2008 онд багийн хүүхдүүдээс маань сургууль соёлд явцгаан З.Түвшинтөр баг бүрдүүлэн Дундговийн нэр дээр тоглож түрүүлэн аймгийнхаа нэрийг гаргаж мөн 2009 онд 2-р байр эзлэн мөнгөн медалийн эзэд болсон билээ.

Ийнхүү эрдэнэт хүлгийнхээ эрэмгий давхилд ид хаваа гайхуулж тоглодог “Морин поло”-гийн Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа оролцож нутаг усныхаа нэрийг гаргасан билээ.

2021.12.23

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын
Морин спорт уяачдын холбооны тэргүүн Н.Загдхорол

“ДЭЛГЭРЭХ ХҮЛЭГ” МОРИН СПОРТ УЯАЧДЫН ХОЛБОО



Аймгуудын УБХТН-ийн дэргэд морин спорт мөн уралдааны асуудал уялдаж байснаа улсын МСУХолбоо шинээр үүсэн байгуулагдаж аймгууд салбар холбоодтой болж эхэлж байсан цаг 1997 оны хавар тухайн үеийн Сумын засаг дарга асан Г.Бөхчулуун дарга дуудаж сумын уяачдын холбоо гэж ТББ байх нь зүйтэй байна иймээс үүнийг удирдаж ажилла гэснээр Малын эмч Ц.Батэрдэнэ ,Г.Сосорбурам, З.Цэдэвсүрэн / Аймгийн алдарт уяач, багш/ нарын хүмүүсийг тэргүүлэгчээр сонгон үйл ажиллагаа явуулж эхэлсэн

билээ.

1998 оны анхны Их-хурд уралдаанд уяач Ц.Хүүхэнбаатар, Ц.Цэрэнбал, Л.Эрдэнэбаатар нар жолоочоор миний бие эртний нийслэл Хархоринг зорьж байсан бол эдгээр эрхэм уяачдын нэг нь Монгол улсын Манлай, хоёр нь Монгол улсын Алдарт уяач болсон байгаа нь тэдний уйгагүй хөдөлмөрийн үр шим,эрдэнэт хүлгийн их буян сумынхаа уяачдыг амжилтанд хөтөлсөн их харгуй байсан бизээ.

Үүний дараа нарийн бичгээр Г.Цогтбаатар сонгогдон бид хавар бүр Холбооны нэрэмжит их насны морьний уралдаан зохион байгуулдаг, жил бүр тухайн жилийн амжилтаар шилдэгүүдээ тодруулан “Ажнайн үүрсээнтэй-Шинэ жил”-ийн баяраа тэмдэглэсэн нь аймагтаа анхдагч нь шахуу байснаа өнөөдөр дурсахад бахдам байна.

Мөн амжилтын үзүүлэлтийг харгалзан Улс, Аймаг, сумын Алдарт ,Манлай уяачын болзол хангасан уяачдын материалыг зохих шатны холбоодод хүргүүлэх ажлыг гүйцэтгэж ирсэнээр тус сумаас Монгол улсын Манлай уяач-1, Монгол улсын-Алдарт уяач-4, Аймгийн Алдарт уяач-12, Сумын алдарт уяач-20 төрөн гарсан хурц түргэн морьд, эрдэм төгс уяачдын өлгий нутаг билээ.



манлайлагч төрийн бус байгууллага юм.

Байгуулагдсан цагаас хойш сумын баяр наадмууд ,нутгийн шүтээн уул хангайн тахилга баяр наадмуудыг тэмдэглэн өнгөрүүлэхэд хурдан морины уралдааныг амжилттай зохион байгуулж, 80 жилийн ойдоо 34 адуу, Монгол улсын манлай харцага Л.Пүрэвжавын цолыг мялаан 12 адуу,Аймгийн 60,70 жилийн ойн баяр наадамд тус бүр 2 адууг манай эрдэнэт хүлгээ дээдлэдэг эрхэм уяачид маань сэтгэлээсээ хандивлан мөн нутгийн зон олны сайн сайханы төлөө хандивын аянуудад нэгдэн ажилладаг сумын

“Дэлгэрэх хүлэг” МСУХолбооны тэргүүн

Баяуд овогт Нямын Загдхорол

ҮНДЭСНИЙ СУРЫН МОНГОЛ УЛСЫН СПОРТЫН МАСТЕР НЯМЛХАГВА ОВОГТОЙ БАЗАРРАГЧАА



Үндэсний сурын спортоор 2018 оноос Хилчин спорт хороо Монгол улсын Б.Ёндон багштай Есүхэй мэргэн үндэсний сурын Даян мэргэн клубт элсч сурын харвааны спортоор хичээллэх болсон.

Тэрбээр 2019 онд Хулд сумын баяр наадамд 1-р байр Сумын мэргэн цол,

Дэлгэрцогт сумын баяр наадамд 4-р байр

Гурвансайхан сумын баяр наадамд 4-р байр

Баянжаргалан сумын баяр наадамд 3-р байр

Улсын баяр наадамд Үндэсний сурын 1-р зэрэг

Дундговь аймгийн Гурвансайхан сум Их газрын чулуу байгалийн цогцолбор газарт зохион байгуулагдсан харваанд 2-р байр

Дорноговь аймагт зохион байгуулагдсан харваа наадмын багийн төрөлд “Говийн бүсийн чуулга” 2-р байр

2020 онд “Мандалговь хүнс” ХХК-ны 25 жилийн ойн баяр наадамд 1-р байр

2020-2021 онд Унгар улсад ажиллаж амьдарсан.

2022 онд Дундговь аймгийн “Нээлтийн харваа”-нд 1-р байр

Эмэгтэйчүүдийн багийн улсын аваргын 3-р байр

Дэлгэрцогт сумын 99 жилийн ойн баяр наадмын 1-р байр

Налайх дүүргийн баяр наадамд 5-р байр / Аймгийн тод харваач цол/

Говь-Алтай аймагт зохион байгуулагдсан Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Спортын мастер цолны болзол хангасан.

Булган аймагт зохион байгуулагдсан “Холимог багийн улсын аварга” шалгаруулах тэмцээнд 1-р байр

Монголын үндэсний 7-р их наадмын багийн төрөлд 2-р байр

Спортын мастер Л.Ядамсүрэнгийн нэрэмжит улсын отго харваанд 2-р байр зэрэг амжилтуудыг гаргаад байна.

“Онч мэргэн” Н.Базаррагчаа нь Дундговь аймгийн Үндэсний сурын багийн тамирчин бөгөөд Дундговь аймгийн Үндэсний сурын шигшээ багт сүүлийн жилүүдэд тогтмол амжилттай харваж амжилт гаргаж яваа чадварлаг тамирчдын нэг билээ.

ДЭЛГЭРИЙН ТЭМЭЭН ПОЛО



Өгүүлэх нь: Дэлгэрийн тэмээн поло баг анх үүссэн түүхийг 2004 оны 01 дүгээр сард сумын засаг дарга Г.Бөхчулуун багийн дарга нарыг дуудаж Аймгийн засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах анхдугаар тэмээн поло тэмцээн, уралдааны удирдамжийг танилцуулж багийн айлуудаас тэмцээний тэмээ, шаардагдах тоног хэрэгсэл, хом шат, буйл зорох, бурантаг томох, хатгуур хануурын багаж, цохиурын мод, тамирчдыг хувцас бэлтгэх, хүн хүчний асуудлыг

шуурхай зохион байгуулахаар тохиролцож амжилттай оролцох шийдвэр гаргасан билээ. Тухайн 2003 оны жилийн эцсийн мал тооллогоор 328 толгой тэмээ тооллуулсан, тэмээгээ өсгөн үржүүлж байгаа өрхийн тоо гарын арван хуруунд багтана.

Ингээд 1-р багийн засаг дарга Ю.Бавуудорж, 2-р багийн засаг дарга Н.Загдхорол, 3-р багийн засаг дарга Б.Баатарсүрэн нар нэн ялангуяа тэмээн пөлогийн тэмээг хаанаас бэлтгэх баг тамирчдыг нэрсийг гаргаж бэлтгэл хангуулахаар хөдөөг зорьж Сумын засаг дарга Г.Бөхчулуун өөрөө явж 3-р багаас эхлэн тэмээтэй өрхтэй тэмээний тоогоо тохирч тэмцээний тамирчдын нэрс гаргаж сумын анхны тэмээн поло тамирчид үүссэн байгуулагдсан түүхтэй.



Тэмээний тоог бүрдүүлэхэд малчин Ц.Эрдэнэ-Очир, Э.Базарпүрэв, Ш.Баярмагнай, Ц.Жаргалсайхан /чимэг/, Ду.Гантөмөр, Ю.Нямсүрэн, Н.Пүрэвдорж, М.Жамбалдорж, М.Адъяабазар, Ц.Хүүхэнбаатар, Ц.Сэнгэдавга, Л.Цэенпэл нар идэвхтэй оролцсон.

2004 оны анхдугаар аймгийн аварга шалгаруулах тэмцээнд бурантаг томох тэмцээнд Ц.Жаргалсайхан /Чимэг/, буйл зорох тэмцээнд Ду.Гантөмөр, хатгуур хануурын багажаар Ц.Жаргалсайхан, Хос

шалгаруулах тэмцээнд Г.Цогтбаатар, Ш.Энхжаргал, тэмээ хомнох тэмцээнд Ш.Баярмагнай, Ц.Жаргалсайхан , хурдан тэмээний уралдаанд М.Жамбалдорж нар амжилттай оролцож байсан.

Тэмээн поло тэмцээний бэлтгэлийг наадмын талбайд бөмбөг цохиж хаалганд оруулах, хамгаалагч хаах, торгуулийн цохилт хийх бэлтгэлийг 2 өдөр хийв.

Аймгийн анхдугаар тэмээн поло тэмцээнд өөрийн аймгийн 15 сум, ӨМӨЗО-ны Шилийн гол хошууны Таванжин ахлагчтай баг тамирчид оролцсон тэмцээн 2 зоонд хуваарьлагдаж тэмцээн эхэлсэн. Эхний өдрийн тоглолтоор Дэрэн, Луус сумын баг тамирчдыг хожиж, 2 дахь өдрийн тоглолтонд Говь угтаал, Сайхан овоо сумын баг тамирчдыг хожиж алт, мөнгөний төлөө тоглох эрхийг авсан. Тамирчид 3-р багийн малчин ахлагч довтлогч Ш.Баярмагнай, довтлогч Ц.Жаргалсайхан /чимэг/, 1-р багийн малчин хаалганы хамгаалагч Ж.Цогтбаатар, 2-р багийн малчин довтлогч Ю.Нямсүрэн, хамгаалагч Н.Пүрэвдорж, хамгаалагч багийн засаг дарга Б.Баатарсүрэн нар өдрийн хоолонд Алтанговь зоогийн газар Аймгийн удирдлагууд, Дэд бүтцийн дэд сайд У.Уламбаяр нартай тааралдаж танай сум хэдэн тэмээтэй болоод ийм сайн тоглоод байна манай сумыг хожвол 300000 төгрөг өгье гэж сайд амлав. Хариуд нь Б.Баатарсүрэн манай сум усны 2 тэмээтэй үлдсэн тэмээгээрээ тоглож явна танай суманд хожигдвол хурдан удмын 6 даага өгье гэж бооцоо тавьж билээ.

Аймгийн аварга шалгаруулах анхдугаар тэмээн поло тэмцээнд Дэлгэрхангай сумын баг тамирчидтай тоглож нэг нэг гоолтой, тоглолтын хугацаа дуусаж торгуулийн цохилтоор Ц.Жаргалсайхан хамгийн сүүлийн бөмбөгийг хаалганд оруулж нэг онооны илүүгээр хожиж “ТЭМЭЭН ПОЛО” тэмцээний Аймгийн аварга Алтан цомын эзэн болсон. Улмаар тэмээн поло тэмцээнийг идэвхжүүлж Г.Цогтбаатар ахлагчтай баг нэмэгдэж Аймгийн аварга шалгаруулах тэмээн поло тэмцээнд 2006 онд 2 баг тамирчид оролцож байв.

Ш.Баярмагнай ахлагчтай баг 2007 онд Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд жагсаалаар нээлтийн ажиллагаанд тэмээтэй оролцож Яармагийн дэнжид 9 аймгийн тэмээн поло тэмцээнд хамгийн хол газраас ирсэн Баянхонгор аймгийн баг тамирчдыг хожиж дараа нь Дорноговь аймгийн багт хожигдсон. Улаанбаатар хот орох, ирэх замыг тэмээн жингээр туулж оролцож байсан.

ДАМИРАНЖАВ ОВОГТОЙ БАТЦЭЦЭГ



Дамиранжав овогтой Батцэцэг 1992 онд Дундговь аймгийн Хулд суманд төрсөн. 1999-2003 онд Дэлгэрцогт сумын дунд сургууль 2003-2007 онд Дундговь аймгийн Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 4 дүгээр сургууль 2007-2009 онд Улаанбаатар хотын “Их Хангай” ахлах сургуулийг төгссөн. Ахлах сургуульд суралцаж байхдаа Монгол хэл бичгийн улсын олимпиадад оролцож түрүүлснээр “Улсын аварга” болж урилгаар Монгол Улсын Их Сургуульд элсэн орж байлаа. Монгол Улсын Их сургуулийг “Монгол судлал” мэргэжлээр Ерөнхий сайдын тэтгэлэгээр 2009-2013 онд суралцан төгсөж, улмаар 2015 онд

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийг “Монгол хэл-Уран зохиол”-ын багш мэргэжлээр 2017 онд Монгол Улсын Их Сургуулийг Мастерийн зэрэгтэй тус тус дүүргэсэн. Одоо Австрали улсад гэр бүлийн хамт мэргэжлээ дээшлүүлэн суралцаж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙН МАЛЧИН ДУЛАМСҮРЭН ОВОГТОЙ ГАНТӨМӨР



Тус сумын Цахиурт багийн Монгол улсын сайн малчин Дуламсүрэн овогтой Гантөмөр нь 1951 онд төрсөн. Ам бүл 2-уул эхнэр Л.Жавзанпагмын хамт мал аж ахуй эрхлэн амьдардаг.

Малчин Ду.Гантөмөр нь 1960-1967 онд Дэлгэрцогт сумын сургуульд сурагч

- 1968-1970 онд “Нэгдмэл хөдөлгөөн” нэгдэлд тэмээчин
- 1970-1973 онд Дархан хотын 017-р ангид хугацаат цэргийн албан хаагч
- 1973-1979 онд “Нэгдмэл хөдөлгөөн” нэгдэлд адуучин

- 1979-1985 онд “Нэгдмэл хөдөлгөөн” нэгдлийн туслах үйлдвэрт мужаан,сүү тосны эрхлэгч
- 1985 оноос одоог хүртэл тасралтгүй 38 жил мал аж ахуйн үйлдвэрлэлд үр бүтээлтэй,санаачлагатай сайн ажиллаж байна.

Нутаг нэгт залуу малчдыг малжуулах,Сум төрийн үйлчилгээний байгуулагууд ахмадууд зэрэгт хандив тусламж байнга үзүүлсээр ирсэн бөгөөд,отор нүүдэл хийх,малдаа тарга хүч авхуулах,түүнийг тогтоох зэрэг арга туршлагаа өөрийн шавь малчиддаа зааж сурган ажиллаж байна.

Өвөлжөө хаваржааныхаа ойр орчмын бэлчээрийг талхлагдахаас хамгаалж 1995 оноос өөрийн хөрөнгөөр бэлчээр хаших ажлыг сумандаа анхлан санаачилж жил бүр нэмсээр 6 га бэлчээрийг хашиж хамгаалаад цаг хүндэрсэн үед ашиглаж байна.

Отор нүүдлээр явахдаа өөрийн санаачилан хийсэн зөөврийн угсардаг хороогоо ашигладаг нь мал сүргээ байгалийн аюулаас хамгаалахад онцгой ач холбогдол өгч байна.

2009 онд түүний бүтээсэн угсардаг зөөврийн хороог МУ-ын ерөнхий сайд Сү.Батболд,ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунай болон бусад албаны хүмүүс газар дээр нь үзэж сонирхоод,цаашид дэлгэрүүлмээр зүйл байна гэдгийг сайшаасан билээ.

Монгол улсын “Сайн малчин”Ду.Гантөмөрийн амжилтыг төр засгаас үнэлж:

- 1975 онд МХЗЭ-ийн “Тэргүүний малчин” алтан медаль
 - 1978,1982,1986 онуудад V,VI, VII таван жилийн гавшгайч
 - 1991,2001 онд Ардын хувьсгалын 70,80-н жилийн ойн медаль
 - 2006 онд Мянгат малчин
 - 2007 онд “Сумын сайн” малчин
 - 2007 онд Аймгийн засаг даргын “Жуух бичиг”
 - 2008 онд “Шилдэг хандивлагч” өрх
 - 2009 онд ХААЯ-ны “Жуух бичиг”
 - 2010 онд “Улсын сайн малчин” цолоор тус тус шагнагдсан байна.
- Монгол улсын сайн малчин Ду.Гантөмөр нь баг хамт олон,сум орон нутагтаа нэр хүндтэй манай багийн тэргүүний ахмад малчдын нэг мөн билээ.



МОНГОЛ УЛСЫН САЙН МАЛЧИН ЛУВСАНДАГВА ОВОГТОЙ ЭРДЭНЭБАЯР

Тус сумын Цахиурт багийн Монгол улсын сайн малчин Лувсандагва овогтой Эрдэнэбаяр нь 1960 онд төрсөн. Ам бүл 2-уул мал аж ахуй эрхэлэн амьдарч байна. Л.Эрдэнэбаяр нь бага наснаасаа эхлэн эцэг эхийгээ даган мал маллах эрдэмд суралцан өнөөг хүртэл мал аж ахуйгаа эрхэлэн, залуу үедээ зааж сургаж яваа манай багийн тэргүүний малчдын нэг билээ.

Л.Эрдэнэбаяр нь өөрийн нэр их хөдөлмөр малч ухаан, өөрт хуримтлуулсан арга туршлагынхаа хүчээр 1998 онд мянгат малчин болж, хурдан хурц морьдоо сум орон нутгийн болон, улс бүсийн наадмуудад уяж сойн айраг түрүү хүртэж, мал маллах, морь уях эрдмээ шавь малчиддаа зааж сургасаар

байна. Үүний нэг жишээ нь түүний шавь малчин Ш.Мөнх-Учрал “Сумын алдарт” уяач болоод байна.

Малчин Л.Эрдэнэбаяр нь өөрийн өсөж төрсөн нутаг их бага Цахирын уул, Баянгийн булаг, Адуун чулуу, Гүн жаргалан, Улаан тойром зэрэг өвс ургамал нь тэгширсэн уужим сайхан нутагт хэдэн үеэрээ мал маллан аж ахуйгаа эрхэлэн, мал сүргээ оторлон жилийн дөрвөн улиралд бэлчээрийг хуваарьтай ашиглаж байна.

Л.Эрдэнэбаяр нь морь уях, мал маллах, арьс нэхий, сур элдэх ардын ухаанд гарамгай суралцсан нэгэн билээ. Тэрээр өөрийн ахан дүүс, болон айл саахалт нутгийн залуучууд болон өөрийн шавь малчиддаа зааж сургах, зөвлөгөө өгөх зэрэг ажлыг байнга хийж явдаг нэгэн билээ.

Морь уях эрдэмд гарамгай суралцсан тэрээр 1994 онд өөрийн унаган Зул хонгор соёолонгоо улсын наадамд гуравт хурдлуулж нутаг орныхоо нэрийг Улсын наадмын зүлэг ногоон дэнж дээр гаргаж, нутгийн ард олноо баярлуулж байсан билээ.

Тэрээр аймаг бүсийн наадмуудад өөрийн унаган хүлгүүдээ айрагдуулж түрүүлгэн 1998 онд “Аймгийн алдарт уяач” хэмээх эрхэм цолыг хүртсэн билээ.

Л.Эрдэнэбаярын хөдөлмөр зүтгэлийг төр засгаас өндрөөр үнэлж:

- 1998 онд “Аймгийн алдарт” уяач
- 2015 онд “Хөдөлмөрийн хүндэт” медаль
- 2022 онд “Алтангадас” одонгоор тус тус шагнагдсан байна.

Малчин Л.Эрдэнэбаяр нь нийгмийн аль ч харилцааны үед зөвхөн өөрийн амин хувийг боддоггүй үргэлж хамт олноо, сум орноо, нутаг усныханаа, ахан дүүсээ гэсэн сэтгэлээр

хандаж, сум багаас зохион байгуулж буй аливаа ажилд үлгэрлэн оролцдог нийгмийн идэвх сайтай, нутаг усандаа нэр хүндтэй манай багийн тэргүүний малчдын нэг билээ.

МОНГОЛ УЛСЫН АВАРГА МАЛЧИН БАЛЖИРЫН ТАГАРВАА



Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Баянбулаг багийн малчин Балжир овогтой Тагарваа нь 1950 онд төрсөн .Б.Тагарваа нь 1962 онд 4-р ангийг төгссөн бүрэн бус дунд боловсролтой. Эцэг эхийн хамт мал маллаж байгаад 1969-1972 онд цэргийн алба хааж, 1972 оноос Дэлгэрцогт сумын “Нэгдмэл хөдөлгөөн ” нэгдэлд адуу маллаж ажил амьдралынхаа гараагаа эхэлсэн бөгөөд 1992 он хүртэл нэгдэл нийгмийн мал маллан, хувьчлалаас хойш өнөөг хүртэл мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна .

1976, 1988 оны зудын жилүүдэд хариуцан маллаж байсан адуун сүргээ алсын оторт гарган хохиролгүй давахын зэрэгцээ олондоо “Адуучин Тагарваа ”гэгдэх

болсон юм.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеэс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үе хүртэлх хугацаанд нэгдэл, нийгмийн мал сүргийн ашиг шимийн даалгаврыг тогтмол 100-105-%иар биелүүлж сум, аймгийн саалийн аваргаар 1981, 1983, 1984, 1985, 1988 онуудад тус тус 5 удаа шалгарч байсан бол 1979-1987 он хүртэл сумын “Энх сүрэгтэн”-ээр тасралтгүй 8 удаа, 100 эхээс бойжуулах төлийн аваргаар 2 удаа тус тус шалгарч байсан байна.

Б.Тагарваа нь 1992 онд зах зээлийн нийгэмд шилжин “Нэгдмэл хөдөлгөөн ” нэгдэл тарах үед хариуцан маллаж байсан адуун сүргээ хувьчлалын хуваарьт тоо ёсоор нь малчид, иргэдэд тараан өгснөөр хувийн мал аж ахуйгаа эрхлэн ирсэн.

Түүний мал аж ахуйд оруулж байгаа хувь нэмрийг төр засгаас өндрөөр үнэлж:

- 1991 онд “Аймгийн аварга малчин ”цол тэмдэг
- 2007 онд ХАА-н яамны “Жуух бичиг”
- 2011 онд Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль
- 2012 онд аймгийн 70 жилийн ойн “Хүндэт тэмдэг”
- 2013 онд “Сумын хүндэт тэмдэг”,
- 2013 онд Төрийн дээд шагнал “Алтан гадас ”одон
- Улсын аюулаас батлан хамгаалах ерөнхий газрын Баярын бичиг
- “Аймгийн Хүндэт тэмдэг”

- 2014 онд “Аймгийн тэргүүний ажилтан ”цол тэмдэг
- 2015 онд МУЗН-ийн дээд шагнал “Нигүүлсэнгүй үйлст манлай малчин ”цол тэмдгээр тус тус шагнажээ .
- 2017 онд “Улсын аварга малчин ”гэр бүл болсон ба профессор малчин цол олгосон байна .
- 2022 онд Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медаль
- 2022 онд Дундговь аймгийн 80 жилийн ойн медаль

МОНГОЛ УЛСЫН АВАРГА МАЛЧИН БАЛДАН ОВОГТОЙ БАЛДОРЖ



Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цахиурт багийн “Улсын аварга” малчин Балдан овогтой Балдорж нь 1964 онд төрсөн. Бүрэн бус дунд боловсролтой. Ам бүл 3-уул эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

Б.Балдорж нь бага наснаасаа эцэг эхийн хамт мал аж ахуйн салбарт ажиллаж амьдарч байгаад 1983-1985 онд цэргийн албыг Өмнөговь аймгийн ХЦ-ийн 0166-р ангид хаасан. 1985 оноос эхлэн тус сумын Нэгдмэл хөдөлгөөн нэгдэлд туслах

ажилтанаар 2 жил үр бүтээлтэй ажиллаж, улмаар 1987 онд нэгдлийн үхэр малласнаар малчин болох гараагаа эхэлсэн байна.

“Нэгдмэл хөдөлгөөн” нэгдэлд түрээсийн гэрээтэй ажиллаж байх хугацаандаа мал маллах арга туршлагыг өөрийн сумын МУ-ын Аварга малчин, Ц. Болоож, Г. Батбазар, МУ-ын сайн малчин Ду.Гантөмөр нарын болон зэргэлдээ сумдын тэргүүний малчдын туршлагыг нэвтрүүлж, мал сүргээ дээд зэргээр таргалуулан, нормт үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж, мал сүргээ өсгөн үржүүлж ажиллахын эх үүсвэр тавигдсан билээ. 1991 оноос түрээсийн гэрээ дуусгавар болж мал хувьчлагдаж цөөн тооны малтай хувийн мал аж ахуй эрхлэн ажиллаж хөдөлмөрлөсөн билээ.

Малчин Б. Балдорж нь нийгмийн аль ч харилцааны үед зөвхөн өөрийн амин хувийг боддоггүй үргэлж хамт олноо, сум орноо, нутаг усныхнаа, ахан дүүсээ гэсэн

сэтгэлээр хандаж, үеийн залуучууддаа өөрийн ажлын арга туршлагаасаа харамгүй хуваалцдаг, баг, сумаас зохион байгуулж буй аливаа ажилд, үлгэрлэн оролцдог, нийгмийн идэвхи сайтай, нутаг усандаа нэр хүндтэй нэгэн билээ.

Б.Балдорж малын үүлдэр угсааг сайжруулахад анхаарч Хэнтий аймгийн Галшар, Сүхбаатар аймгийн Уулбаян, Эрдэнэцагаан сумаас азарга, гүү, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумаас сүү махны чиглэлийн үнээ, бух, Сүхбаатар, Дорнод, Төв аймгаас хуц, Хөвсгөл, Өмнөговь Төв аймгаас ухна, мөн нутгийн шилмэл малаа авч үржилд ажиглаж байна. Үүний үр дүнд үхэр, хонины мах, ямааны ноолуурт чанарын болон жингийн ахиц гарч ашиг шим нь нэмэгдэн, орох орлого нь ч өссөн байна.

Б.Балдорж нь өөрийн эзэмшсэн мал эмчлэх ардын уламжлалт аргаа ашиглан сумын “Дэлгэрбаяндалай” ХХК мал эмнэлэгтэй гэрээ байгуулан ажиллаж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд өөрийн мал сүргийг бүрэн хамруулахын зэрэгцээ малдаа мал эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй үзүүлж чаддагаас жил дараалан малын өвчлөл, хорогдол гаргадаггүй байна.

Мал маллах уламжлалт арга туршлага, отор нүүдэл хийх, байгаль дэлхийгээ шинжлэх, арга ухааныг ахмад малчдаас суралцаж, түүнийгээ залуучуудад сургахад онцгой анхаарч өөрийн хоёр хүү залуу малчин Б.Бадамсамба, Б.Бадамхүү нарыг отор нүүдэл хийх, малынхаа хариулга маллагааг байгаль цаг агаарын байдалд тохируулан маллах талаар сурган дадлагажуулж байна. Эдгээр малчид ч өөрсдийн гэсэн арга барилтай болж том хүү Б.Бадамсамба, бага хүү Бадамхүү нар нь улмаар бие даан мал аж ахуйгаа амжилттай эрхэлж сумын “Мянгат малчин” Сумын сайн малчин болоод байна. Б.Балдорж нь бух, хуц, ухнандаа хэмжилт хийлгэн стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг ялган, тэмдэглэгээ хийлгэж бүртгэл мэдээллийн санд бүртгүүлжүүлээд байна.

Б.Балдоржийн хөдөлмөрийн амжилтыг үнэлж:

- 2001 онд “Тэргүүний малчин”
- 2002 онд “Тэргүүний малчин залуу” алтан медаль
- 2003 онд Аймгийн Засаг Даргын “Жуух бичиг”
- 2008 онд “Сумын сайн малчин”
- 2012 онд “Аймгийн сайн малчин”
- 2011 онд “Сумын шилдэг хандивлагч”

- 2013 онд Төрийн дээд шагнал “Алтан гадас” одон
- 2015 онд “Нигүүлсэнгүй Манлай малчин” алтан медалиар
- 2017 онд Мал аж ахуйн хүндэт “Профессор” цол
- 2020 онд “Монгол улсын аварга малчин” цол тэмдэгээр тус тус шагнагдсан байна. Орчин үеийн ололт амжилт, ахмад малчдын туршлагыг бүтээлчээр эзэмшиж, байгаль цаг уурын эрс өөрчлөлттэй өнөөгийн нөхцөлд, өөрийн мал маллах ажиллагааг оновчтой зөв удирдан түүнийгээ залуучуудад эзэмшүүлж, Улс, аймгийн “Аварга малчин” цол тэмдэг, төрийн дээд шагнал “Алтан гадас” одон хүртэж, өөрийн хоёр хүү Б.Бадамсамба, Б.Бадамхүү нарт малч ухаанаа өвлүүлэн малчин болгож, жилээс жилд амжилт нь өсөж байгаа нутаг усандаа нэр хүндтэй малчин билээ.

МОНГОЛ УЛСЫН АВАРГА МАЛЧИН ГАНГАР ОВОГТОЙ ГАНСҮХ



Тус сумын Цахиурт багийн малчин Баяуд овогт Гангарын Гансүх нь 1977 онд төрсөн. Бүрэн бус дунд боловсролтой. Өрхийн дотор ам бүл 5-уул, эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.

Г.Гансүх нь бага насаа аав, ээжийн гар дээр мал аж ахуй дээр өнгөрүүлж 1985-1993 онд Дэлгэрцогт сумын 8 жилийн сургуулийн 8-р ангийг амжилттай төгсөж, өөрийн саналаар малчин болж 1994 оноос хойш 30-аад жил тасралтгүй мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна.

Мал маллагаандаа өөрийн аав О.Гангар, МУ-ын Сайн малчин Д.Гантөмөр нарын болон зэргэлдээ сумын тэргүүний малчдын тэргүүн туршлагыг нэвтрүүлж, малаа дээд зэргээр таргалуулж оны эхний 100 эхээс 100-аас дээш төл бойжуулж иржээ.

Малчин Г.Гансүх нь нийгмийн аль ч харилцааны үед зөвхөн өөрийн амин хувийг боддоггүй үргэлж хамт олноо, сум орноо, нутаг усныханаа, ахан дүүсээ гэсэн сэтгэлээр хандаж үеийн залуучууддаа өөрийн ажлын туршлагаа харамгүй хуваалцдаг, баг

сумаас зохион байгуулж буй аливаа ажилд үлгэрлэн оролцдог, нийгмийн идэвхи сайтай, нутаг усандаа нэр хүндтэй нэгэн билээ.

Г.Гансүх эхнэр Н.Өлзийжаргал болон хүүхдүүдийн хамт малын сааль сүүгээ бүрэн ашиглаж чанартай цагаан идээ боловсруулан “Дундговь түншлэл”2016, 2017, 2018, 2022 болон өөрийн сумын Үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцож сумаасаа “Хамгийн сайхан” айрагтай өрхөөр шалгараад,”Дундговь түншлэл” үзэсгэлэн худалдаанд тогтмол орлцож аймагтаа хамгийн сайхан айрагтай өрхөөр 3 дахь удаагаа шалгараад байна.

Г.Гансүхийн айраг нь Дэлгэрцогт сумынхаа брэнд айраг болоод байна.

Мал маллах арга туршлага, отор нүүдэл хийх, байгаль дэлхийгээ шинжих арга ухааныг ахмад малчдаас суралцаж түүнийгээ залуучуудад сургахад онцгой анхаарч залуу малчин Д.Гомбосүрэн, Б.Жамбалдорж нарыг отор нүүдэл хийх, малынхаа хариулга маллагааг байгаль цаг агаарын байдалд тохируулан маллахад сурган дадлагажуулж байна. Эдгээр малчид ч өөрсдийн гэсэн арга барилтай болж бие даан мал аж ахуйгаа амжилттай эрхэлж байна.

Г.Гансүхийн хөдөлмөр амжилтыг үнэлж “Сумын сайн малчин”,Тэргүүний залуу алтан медаль,Аймгийн алдарт уяач, Сумын Засаг даргын Жуух бичиг, Аймаг байгуулагдсаны 70,80-н жилийн ойн медаль, “Хөдөлмөрийн хүндэт медаль,” Монгол улсын аварга” малчин цол, Монголын морин спорт уяачидын холбооны Эрдэнийн очир тэмдэгээр тус тус шагнагдсан байна.

Өөрийн эцэг эхийн мал аж ахуй эрхэлж ирсэн уламжлалыг нэр төртэй залгамжлан эзэмшсэн мэргэжилдээ тулгуурлан орчин үеийн шинжлэх ухааны ололт, ахмад малчдын туршлагыг бүтээлчээр эзэмшиж, цаг уурын эрс өөрчлөлттэй өнөөгийн нөхцөлд өөрийн мал маллах ажиллагааг оновчтой зөв удирдан түүнийгээ залуучуудад эзэмшүүлж, жилээс жилд амжилт нь өсч байгаа нутаг усандаа нэр хүндтэй, залуу малчин юм

“Улсын аварга малчин” Г.Гансүхийн 30-аад жил тасралтгүй мал аж ахуй эрхэлж, зах зээлийн харилцааны үед мал маллах, өөрийн гэр бүлийн амьдралыг хангалттай авч явахын зэрэгцээ бусдын амьдралд тус дэм болж, ажлын байр бий болгох, сум орноо хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа малчин билээ.

МОНГОЛ УЛСЫН ЗАЛУУ АВАРГА МАЛЧИН

ДАШ ОВОГТОЙ НЯМСҮРЭН



Тус сумын Цахиурт багийн Монгол улсын аварга малчин Даш овогтой Нямсүрэн нь 1964 онд төрсөн бүрэн бус дунд боловсролтой. Өрхийн дотор ам бүл 5-уул эхнэр хүүхдүүдийн хамт мал аж ахуй эрхэлэн амьдарч байна.

Монгол улсын залуу аварга малчин Д.Нямсүрэн нь 8-р ангиа төгсөөд өөрийн хүсэлтээр илгээлтийн эзэн болж “Нэгдмэл хөдөлгөөн нэгдэлд” адуучин болж малчин болох ажлын гараагаа эхэлсэн байна.

Д.Нямсүрэн нь 1980-1982 оны хооронд Цахиурт бригадад адуу маллаж байгаад 1982 онд цэргийн албанд татагдсан байна. 1982-1985 оны хооронд ХЦ-ийн 0151-р ангид цэргийн албыг нэр төртэй хааж ирээд сумандаа адуу маллаж эхэлсэн байна.

Д.Нямсүрэн нь нэгдэл нийгмийн адууг олон жил үр бүтээлтэй маллаж төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед малын тоо толгойг өсгөж, норма төлөвлөгөөгөө тогтмол биелүүлж унага бойжуулалт, сүү сааль, дэл сүүл, хөөврийн аварга удаа дараа болж байсан тэргүүний адуучин залуусын нэг байсан

Д.Нямсүрэн нь нэгдэл нийгмийн олон адууг адгуулан маллахын зэрэгцээ өөрийн унаган хурц хурдан морьдоо аймаг сумынхаа наадамд уяж сойн уралдуулж олон айраг түрүү авсан уяач хүн билээ.

Д.Нямсүрэн нь залуу хойч үедээ адууг хэрхэн маллах, морь уях эрдмээ харамгүй хэлж зааж сургаж байдаг хамт олон, нутаг усандаа нэр хүндтэй нэгэн билээ.

Улсын залуу аварга малчин Д.Нямсүрэнгийн хөдөлмөр амжилтыг нь үнэлж:

- 1986, 1988 онуудад “Энх мэнд сүрэгтэн”
- 1987 онд Залуучуудын холбооны мөнгөн медаль
- 1987, 1991 онуудад VII, VIII 5-н жилийн гавшгайч
- 1988 онд “Аймгийн аварга малчин”
- 1988 онд Аймгийн засаг даргын “Жуух бичиг”
- 1989 онд Засгийн газрын “Хүндэт жуух бичиг”
- 1990 онд “БНМАУ-ын залуу аварга малчин”
- 2009 онд “Мянгат малчин”
- 2010 онд ХХААЯамны “Тэргүүний ажилтан”
- 2010 онд ХХААЯамны тэргүүн
- 2016 онд “Аймгийн алдарт уяач” зэрэг цол тэмдэгээр шагнагдсан байна.

Д.Нямсүрэн нь мал сүргийнхээ чанарыг сайжруулах,эрүүл мэндийг хамгаалах үүднээс мал эмнэлэгийн арга хэмжээнд мал сүргээ тогтмол хамруулж,өөрийн малын эрүүл мэндийн дэвтэртээ тогтмол тэмдэглэгээ хийлгэж,отор нүүдлээр явахдаа тухайн нутаг орны малын эмчтэй холбоотой